

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛОгноо: **2024.02.05**№ **24/13**

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46, 47, 76 дугаар зүйлийн 76.1.12 дэх заалт, 80 дугаар зүйлийн холбогдох заалтууд, Банкны тухай хуулийн 29, 35 дугаар зүйл, Богд банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 22/125 тоот тогтоолын арван дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Богд Банк ХК-ийн Ногдол ашгийн журам”, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурлаар шийдвэрлэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Богд Банк” ХК нь 2023 оны 2-р хагас жилийн санхүүгийн урьдчилсан байдлаарх татварын дараах цэвэр ашиг болох **14,087,009,836.16** төгрөгийн **25%** болох **3,521,752,459.04** төгрөгийн ногдол ашгийг нийт эргэлтэд байгаа хувьцаанд тооцон мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Нэг төрлийн хувьцаанд ногдох ногдол ашгийн дүнг адил хэмжээнд байхаар тогтоосугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
4. Ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж болон Үнэт цаасны компаниудаар дамжуулан эрх бүхий этгээдийн зөвшөөрөл шийдвэр ирснээс хойш 60 хоногийн дотор ногдол ашгийг хуваарилсугай.
5. Энэхүү тогтоолыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх Захирал /Г.Саруул/ -д үүрэг болгосугай.
6. Тогтоолын хувийг Монголбанк, Санхүүгийн Зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Саруул)-д даалгасугай.
7. Ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Саруул)-д даалгасугай.
8. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга (Л.Болдхуяг)-д үүрэг болгосугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА****Л.БОЛДХУЯГ**